

Golomt Capital®

# Дотоодын Зах Зээлийн

ДОЛОО  
ХОНОГИЙН  
ТОЙМ

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК- Д БЭЛТГЭВ

2022.01.10

Анхаарлын төвд

## Индексийн өдрийн өөрчлөлт



МХБ ИНДЕКС	7 хоног	1 сар	1 жил
TOP 20	-1.47%	10.0%	130.0%
MSE A	1.92%	12.8%	73.8%
MSE B	1.06%	3.6%	67.1%

	Дүн (сая.төг)	Өөрчлөлт %
Зах зээлийн үнэлгээ	6,054,586.9	4.1%
Арилжигдсан дүн	23,994.9	-33.94%

ИХ АРИЛЖААЛ АГДСАН	Хаалтын ханш	Үнийн дүн
Ард Санхүүгийн Нэгдэл	8,990	3,011,600,710
АПУ	1,894	1,225,423,454
Монос Хүнс	113.08	369,170,646
Даваанбулаг	196.65	392,641,446
Улсын Их Дэлгүүр	3,300	351,239,506

ӨНДӨР ӨСӨЛТТЭЙ	Хаалтын ханш	Өөрчлөлт %
Мандал Говь Импекс	370	65.00%
Монноос	10,100	62.06%
Мандал Даатгал	22.36	42.99%
Стандарт Ноос	1,750	27.03%
Түшиг Уул	3,781	25.00%

## АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ | 2022/01/03-01/07

- Тайлант долоо хоногт МХБ-ийн арилжаагаар нийт 83 төрлийн 24.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 11,126,290 ширхэг үнэт цаасны арилжаа хийгдлээ.
- Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 6,055 тэрбум төгрөг болсон бол ТОП-20 индекс 43,757 нэгж болж өнгөрсөн долоо хоногоос 1.47%-иар буурсан байна. Түүнчлэн MSE A индекс 15,780 нэгжид хүрч 1.92%-иар өссөн бол MSE B индекс 12,332 нэгжид хүрч өмнөх долоо хоногоос 1.06 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- Хамгийн өндөр өсөлтийг Мандал Говь Импекс (MNG) 65.00%, Монноос (MNS) 62.06%, Мандал Даатгал (MNDL) 42.99% -иар тус тус үзүүллээ.
- Хамгийн их уналтыг Авто Импекс (AOI) – 15.00%, Нэхээсгүй Эдлэл ХК (NXE) -14.72%, Улсын Их Дэлгүүр (UID) -12.72%-иар тус тус үзүүллээ.

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

**Сүү ХК 2021 оны хагас жилийн ногдол ашигт нэгж хувьцаанд 5.14 төгрөгийн ногдол ашиг хуваариллаа**

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж  
Сүү ХК 2021 оны эхний хагас жилийн ашгаа хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг олгохоор болжээ. Тодруулбал, компанийн мөн хугацаанд 5.89 тэрбум төгрөг буюу нэгж хувьцаандаа EPS = 17.15 төгрөгийн цэвэр ашиг олсон бөгөөд үүнээс 1.7 тэрбум төгрөг буюу нэгж хувьцаанд 5.14 төгрөгийн ногдол ашиг олгохоор болсон юм.

## 2021 онд 42,899 иргэн хөрөнгийн зах зээлд оролцохоор шинээр данс нээлгэжээ

Эх сурвалж: Market Info

- ✓ 2021 онд Монголын Биржүүдийн Нэгдсэн Холбоог Монголын Хөрөнгийн Бирж (MSE), Улаанбаатар Үнэт Цаасны Бирж (UBX) болон Digital Assets Exchange (DAX), Coinhub, Trade.mn зэрэг виртуал хөрөнгийн биржүүд хамтран байгуулсан.
- ✓ Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Степ голд /STGO/ компани 2022 ондоо багтаж дотоодын хөрөнгийн биржид давхар бүртгүүлж, олон нийтэд хувьцаагаа санал болгохоор ажиллаж байгаа гэж СЗХ-ны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн мэдээлсэн.
- ✓ 2021 онд дотоод, гадаадын нийт 42,899 иргэн, аж ахуйн нэгжүүд хөрөнгийн зах зээлд орохоор шинээр данс нээлгэсэн талаар ҮЦТХТ-өөс мэдээллээ.
- ✓ Лэндмн ББСБ /LEND/ нь 2021 онд 34.2 сая ширхэг хувьцааг худалдан авч халаасласан байна.

Их уналттай	Хаалтын ханш	Өөрчлөлт %
Авто Импекс	3,400	<b>-15.00%</b>
Нэхээсгүй Эдлэл	1,750	<b>-14.72%</b>
Улсын Их Дэлгүүр	3,300	<b>-12.72%</b>
Булган Ундрага	149,700	<b>-9.22%</b>
Увс чацаргана	410	<b>-8.89%</b>

ӨНДӨР ҮНЭЛГЭЭТЭЙ ТОП-5	Хаалтын ханш	Үнэлгээ, тэрбум. Төг
АПУ	1,894	<b>2,013.3</b>
Тавантолгой	7,500	<b>395.0</b>
МИК	14,500	<b>300.3</b>
Инвескор ББСБ ХК	4,151	<b>297.7</b>
Эрдэнэ Ресурс Девелопмент	927	<b>270.5</b>

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
Инфляцын түвшин	10.5%
Бодлогын хүү	6.0%
Хадгаламжийн дундаж хүү (төгрөг)	5.4%
Хадгаламжийн дундаж хүү (ам.доллар)	1.6%
Зээлийн дундаж хүү (төгрөг)	14.5%
Зээлийн дундаж хүү (ам.доллар)	8.3%

## ХАРИЛЦАГЧИЙН БОЛОВСРОЛД: ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ ВАЛЮТЫН ХАНШИД ХЭРХЭН НӨЛӨӨЛДӨГ ВЭ

Төлбөрийн тэнцэл нь тухайн валютын эрэлтэд нөлөөлөх замаар ханшид нөлөөлдөг. Экспортлогч орнууд нь импортоосоо давсан экспортын орлоготой байдаг тул тухайн орны мөнгөн тэмдэгтийн эрэлт нэмэгддэг байна. Харин импортлогч орнуудын хувьд тухайн орны мөнгөн тэмдэгтийн эрэлт бага байдаг. Тухайлбал төлбөрийн тэнцэл нь тухайн улсын валютын орох болон гарах урсгал хоорондын зөрүүг илэрхийлдэг үзүүлэлт юм. Төлбөрийн тэнцэл эерэг гарах нь валютын ханш тогтвортой байх гол хүчин зүйл болдог. Иймд манай улс төгрөгийн бусад валюттай харьцах ханшаа тогтвортой хадгалахын тулд экспортоо нэмэгдүүлэх шаардлагатай юм.

## ЭДИЙН ЗАСГИЙН МЭДЭЭЛЭЛ

### Ам.долларын төгрөгтэй харьцах ханш 2022 онд бага зэрэг чангарна

Эх сурвалж: Монголбанк, Голомт Капитал

Төлбөрийн тэнцэл нь тухайн улсын валютын орох болон гарах урсгал хоорондын зөрүүг илэрхийлдэг үзүүлэлт юм. Харин Улсын валютын нөөц нь Монголбанк болон арилжааны банкны эзэмшилд байгаа валютаарх төлбөрийн хэрэгсэл, үнэт метал болон бусад үнэт цааснаас бүрдэнэ. Төлбөрийн тэнцэл дээр ашигтай гарвал Монгол улсын валютын нөөц ихсэж төлбөрийн чадвар сайжирч, төгрөг чангарч, валютын ханш буурах сайн талтай байдаг.

Тэгвэл 11 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр төлбөрийн тэнцэл 131.9 сая ам.долларын ашигтай гарсан ч эхний 11 сарын хуримтлагдсан байдлаар төлбөрийн тэнцлийн алдагдал 436.5 сая ам.доллар болоод байна.

### 2021 оны хувьд төлбөрийн тэнцэл 370 сая ам.долларын алдагдалтай гарахаар байгаа нь 2020 онд 787 сая ам.долларын ашигтай гарснаас доогуур үзүүлэлт боллоо.

Харин Гадаад валютын албан нөөц 2021 оны 11 дүгээр сарын эцэст 4.1 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар өссөн ч **2021 оны 4 дүгээр сард дээд түвшиндээ хүрснээс хойш тогтмол буурсаар байна.** Түүнчлэн гадаад өрийн дарамт өндөр байгаатай холбоотойгоор **албан нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатайг** Монголбанк онцолж байна.

Иймд төлбөрийн тэнцэл 2021 онд алдагдалтай гарах хүлээлттэй байгаа, албан нөөц нэмэгдүүлэх үүднээс гадаад валютын эрэлт өндөр байх зэрэг шалтгаануудын улмаас өмнөх онд тогтвортой байсан ам.долларын ханш бага зэрэг чангарах магадлалтай байна.

### 2022 онд эдийн засаг 5.5 хувиар өсөх төлөвтэй байгааг Монголбанкнаас онцоллоо

Эх сурвалж: Монголбанк

Монголбанкны тооцооллоор 2022 онд эдийн засаг 5.5 хувиар өсөх төлөвтэй байна. 2021 онд эдийн засгийн идэвхжил нэмэгдсэн ч хилийн боомтуудад үүсээд буй логистикийн асуудлууд нь гадаад худалдааны эргэлтийг хязгаарлаж, сэргэлтэд сөргөөр нөлөөлж байна. Монголбанк 2021 онд дотоодын эдийн засаг 4 хувиар өснө гэж тооцоолоод байгаа юм. Харин 2023 онд өсөлт 5.6 хувь болно гэж тооцоолжээ. Гэсэн хэдий ч 2022 онд түүхий эдийн үнийн өсөлт 2021 оны түвшинд хүрэхээргүй байгаа учир манай улс экспортын биет хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.


## АРИЛЖААНЫ БАНКУУДЫН 2021 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Балансын үзүүлэлтүүд, тэрбум төгрөгөөр	Хаян	ХХБ	Голомт	Төрийн	Хас	Калитрон	Транс	Чингис Хаан	Богд	Үндэсний хөрөнгө оруулалт	Арил
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,404.5	2,118.4	1,893.7	879.7	447.3	278.8	122.4	0.6	99.6	1.0	1.8
Зээл (цэвэр дүнгээр)	6,334.7	4,480.5	3,386.6	2,235.3	1,577.0	578.0	388.0	198.5	137.6	2.9	14.5
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>13,144.4</b>	<b>9,307.1</b>	<b>7,596.1</b>	<b>3,747.5</b>	<b>3,435.0</b>	<b>1,085.4</b>	<b>656.9</b>	<b>308.1</b>	<b>295.5</b>	<b>134.1</b>	<b>84.1</b>
Харилцах	2,414.8	1,763.2	1,491.5	571.1	499.9	134.2	23.7	158.9	25.5	104.3	1.1
Хадгаламж	7,764.5	3,787.9	3,590.9	2,308.8	1,753.3	574.6	222.4	57.6	101.3	35.3	28.0
<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>11,846.2</b>	<b>8,212.4</b>	<b>7,004.4</b>	<b>3,363.1</b>	<b>3,118.4</b>	<b>972.0</b>	<b>485.3</b>	<b>293.9</b>	<b>225.5</b>	<b>170.0</b>	<b>46.8</b>
Хувь нийлүүлсэн хөрөнгө	172.1	72.7	194.7	178.0	55.3	86.0	146.5	42.7	50.0	35.1	50.0
Хуримтлагдсан ашиг, алдагдал	955.3	610.2	165.5	160.7	198.5	18.1	25.1	-29.3	18.6	-75.3	-12.9
<b>Өөрийн хөрөнгийн дүн</b>	<b>1,298.2</b>	<b>1,094.7</b>	<b>591.7</b>	<b>384.4</b>	<b>316.6</b>	<b>113.4</b>	<b>171.6</b>	<b>14.2</b>	<b>70.0</b>	<b>-35.9</b>	<b>37.3</b>
<b>Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн</b>	<b>13,144.4</b>	<b>9,307.1</b>	<b>7,596.1</b>	<b>3,747.5</b>	<b>3,435.0</b>	<b>1,085.4</b>	<b>656.9</b>	<b>308.1</b>	<b>295.5</b>	<b>134.1</b>	<b>84.1</b>
Чанаргүй зээлийн хувь	5.29%	12.70%	7.10%	9.91%	5.42%	9.62%	3.19%	20.00%	3.31%	96.65%	-
<b>Орлогын үзүүлэлтүүд, тэрбум төгрөгөөр</b>											
Хүүгийн орлого	866.5	456.3	426.4	275.6	231.0	69.0	33.3	17.4	18.6	22.0	4.7
Хүүгийн зардал	425.2	304.4	258.1	144.6	131.5	45.8	16.4	4.0	7.7	1.9	2.0
<b>Хүүгийн цэвэр орлого</b>	<b>441.3</b>	<b>151.8</b>	<b>168.3</b>	<b>131.0</b>	<b>99.6</b>	<b>23.1</b>	<b>16.9</b>	<b>13.5</b>	<b>10.9</b>	<b>20.1</b>	<b>2.7</b>
Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого	421.2	103.3	126.6	105.8	99.1	8.8	17.6	14.5	10.0	-2.5	-0.3
Бусад орлого	210.1	144.8	70.6	27.5	28.7	12.2	3.0	0.8	7.0	80.1	2.0
Бусад зардал	324.7	170.5	174.2	87.3	68.6	20.0	9.7	7.9	8.2	39.4	0.0
<b>Татварын дараах ашиг, алдагдал</b>	<b>229.5</b>	<b>77.5</b>	<b>17.7</b>	<b>39.7</b>	<b>41.0</b>	<b>1.0</b>	<b>9.5</b>	<b>6.4</b>	<b>8.4</b>	<b>38.2</b>	<b>-1.9</b>
<b>Шалгуур харьцаа үзүүлэлтүүд</b>											
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа >9%	15.10%	15.20%	12.20%	15.27%	16.50%	14.18%	35.30%	2.97%	36.91%	-25.60%	72.18%
Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа >12%	15.10%	15.20%	12.50%	15.27%	16.50%	14.18%	35.30%	2.97%	36.91%	-25.60%	72.18%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт >20%	49.09%	39.17%	35.13%	33.54%	49.70%	31.73%	35.40%	-11.60%	35.72%	0.60%	106.85%
Гадаад валютын нээлттэйпозици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) <+-15%	2.18%	-11.30%	8.88%	8.65%	2.50%	6.94%	-4.30%	-47.70%	2.64%	22.00%	-3.89%
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа <+-30%	2.22%	-16.41%	17.54%	10.24%	3.30%	11.72%	-4.40%	-69.30%	2.76%	37.20%	-3.89%

Эх сурвалж: Арилжааны банкуудын албан ёсны вебсайт

## МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Бодит Дотоодын Нийт Бүтээгдэхүүн, тэрбум төгрөгөөр



Бодит сектор (их наяд төгрөг)	2020Q3	2021Q3	Өөрчлөлт, дүнгээр	Өөрчлөлт, хувиар
Нэрлэсэн ДНБ	26.6	29.6	2.7	10.1%
Бодит ДНБ, 2015 зэрэгцүүлэх үнээр	18.8	19.5	0.7	3.7%
Бодит ДНБ өсөлт	-6.7%	3.6%	10.3%	-
Ажилгүйдлийн түвшин	6.6%	8.8%	2.2%	-
Инфляцын түвшин	1.7%	9.6%	7.9%	-
Гадаад сектор (сая ам.доллар)*				
Гадаад худалдааны эргэлт	9,075.2	11,531.3	2,456.1	27.1%
Экспортын хэмжээ	5,147.0	6,404.7	1,257.7	24.4%
Импортын хэмжээ	3,928.1	5,126.6	1,198.5	30.5%
Гадаад худалдааны тэнцэл	1,218.9	1,278.2	59.3	4.9%
Нүүрсний экспорт	1,166.1	460.0	-706.1	-60.6%
Алтны экспорт	1,166.3	2,307.3	1,141.0	97.8%
Зэсийн экспорт	1,477.4	1,517.1	39.7	2.7%
Төсвийн сектор (их наяд төгрөг)				
Тэнцвэржүүлсэн орлого	6.7	9.7	2.3	44.2%
Тэнцвэржүүлсэн зарлага	9.4	10.9	1.5	15.9%
Тэнцвэржүүлсэн тэнцэл	(2.7)	(1.2)	1.7	-53.3%
Мөнгөний сектор (их наяд төгрөг)				
Мөнгөний нийлүүлэлт	22.4	27.0	4.6	20.3%
Нийт хадгаламж	14.6	18.6	14.0	27.6%
Нийт харилцах	5.0	7.0	2.0	39.6%
Нийт зээлийн үлдэгдэл	18.1	21.8	3.7	20.4%
Хугацаа хэтэрсэн зээл	1.1	1.1	0.0	-0.1%
Чанаргүй зээл	1.7	1.8	0.1	1.6%
Чанаргүй зээлийн хувь	10.1%	8.8%	1.3%	-
Бодлогын хүү	8%	6%	-2.0%	-

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Монголбанк, Сангийн Яам

## ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Симбол	APU	AIC	AARD	BODI	GOV	INV	LEND	MNDL	MFC	SUU	TTL	TUM
Компаний н нэр	АПУ	Ард Даатгал	Ард Санхүүгийн н Нэгдэл	Бодь Даатгал	Говь	Инвекстор ББСБ	ЛендМН ББСБ	Мандал Даатгал	Моноос Хүнс	СУУ	Таван Толгой	Түмэн Шувуут
Салбар	Хүнсний Үйлдвэрлэл	Санхүү	Санхүү	Санхүү	Хүнсний Үйлдвэрлэл	Санхүү	Санхүү	Санхүү	Хүнсний Үйлдвэрлэл	Хүнсний Үйлдвэрлэл	Уул уурхай	Хөдөө аж ахуй
Хаалтын ханш	1,715	1,337	9,120	153.9	324.7	3,300	40.9	99.9	105.8	410	7,495	421
<b>САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД (тэрбум төгрөг)</b>												
Хөрөнгө	595.5	34.3	451.9	32.0	412.8	156.0	32.2	65.5	19.9	78.3	99.7	37.6
Өр төлбөр	114.2	16.5	67.5	19.0	366.7	96.7	13.9	41.3	6.4	43.4	50.2	7.8
Эздийн өмч	481.3	17.8	384.3	12.9	46.1	59.3	18.2	24.3	13.4	34.9	49.5	29.8
Борлуулалтын орлого	305.0	7.4	9.3	13.8	39.6	15.7	0.1	22.6	7.5	51.1	68.8	20.3
Цэвэр ашиг	81.3	6.7	4.5	0.6	(19.7)	7.3	1.8	3.2	0.5	5.9	1.9	4.5
<b>ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>												
Эргэлтийн харьцаа	2.9	1.9	9.1	1.6	0.7	1.8	5.3	1.6	1.2	2.1	1.7	2.5
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	1.8	1.9	9.1	1.6	0.7	1.8	5.3	1.5	0.7	1.1	1.3	1.7
Өр ба хөрөнгийн харьцаа	19%	48%	15%	60%	89%	62%	43%	63%	32%	55%	50%	21%
Өр ба өмчийн харьцаа	24%	93%	18%	147%	795%	163%	77%	170%	48%	124%	101%	26%
Хөрөнгийн өгөөж	14%	20%	1%	2%	-5%	5%	6%	5%	3%	8%	2%	12%
Эздийн өмчийн өгөөж	17%	38%	1%	5%	-43%	12%	10%	13%	4%	17%	4%	15%
Нийт ахиуц ашиг	50%	86%	100%	71%	45%	88%	-792%	45%	45%	28%	7%	32%
Цэвэр ахиуц ашиг	27%	91%	49%	4%	-50%	47%	1,995%	14%	7%	12%	3%	22%
<b>P/E*</b>	<b>12.4</b>	<b>2.5</b>	<b>28.6</b>	<b>29.4</b>	<b>(6.2)</b>	<b>20.4</b>	<b>8.8</b>	<b>13.5</b>	<b>46.2</b>	<b>17.5</b>	<b>103.9</b>	<b>16.3</b>
<b>P/B*</b>	<b>4.2</b>	<b>1.8</b>	<b>0.7</b>	<b>2.7</b>	<b>5.3</b>	<b>5.0</b>	<b>1.7</b>	<b>3.6</b>	<b>3.5</b>	<b>5.9</b>	<b>8.0</b>	<b>4.9</b>
<b>P/S*</b>	<b>3.3</b>	<b>2.2</b>	<b>13.8</b>	<b>1.3</b>	<b>3.1</b>	<b>9.5</b>	<b>159.2</b>	<b>1.9</b>	<b>3.1</b>	<b>2.0</b>	<b>2.9</b>	<b>3.6</b>

\*P/E, P/B, P/S харьцаа үзүүлэлтийг тооцоход:

- Хувьцааны ханшийг 2022 оны 1-р сарын 7-ны өдрөөр;
- Нийт компаниудын борлуулалтын орлого болон цэвэр ашгийг тооцохдоо 2021 оны хагас жилийн үр дүнд үндэслэн тооцсон 2021 оны эцсийн байдлаарх таамагласан дүнг ашиглав.
- Эздийн өмчийг 2021 оны эхний хагас жилийн байдлаарх дүнгээр тооцсон.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Голомт Капитал ҮЦК тооцоолол

**МЭДЭГДЭЛ**

Энэхүү мэдээлэл нь Голомт Капитал ҮЦК ХХК-иас зөвхөн мэдээллийн зорилгоор бэлтгэгдсэн болно. Илэрхийлсэн үзэл бодол нь зөвхөн шинжээчийн байр суурь бөгөөд зах зээл болон бусад хүчин зүйлсийн нөлөөллөөр өөрчлөгдөх боломжтой юм. Ямар нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон бусад төрлийн зөвлөмж өгөх шинж агуулаагүй болно. Үүнд үнэт цаасыг авах эсвэл зарахыг сэдэлжүүлсэн эсвэл арилжаа болон хөрөнгө оруулалтын ямар нэг стратегийг санал болгоогүй.

Бүх мэдээ, мэдээллүүд, үүнд Голомт Капитал ҮЦК ХХК-ийн эх сурвалж болгосон буюу гаргасан мэдээлэл, үнэн бодит гэж үзсэн эх сурвалжаас авсан боловч нарийвчлал нь баталгаажуулаагүй болно. Өнгөрсөн үзүүлэлт нь ирээдүйн үр дүнгийн баталгаа болохгүй. Тиймээс та өөрт нийцсэн хөрөнгө оруулалт эсвэл арилжаа хийхдээ бие даан буюу өөрийн зөвлөлтэйгөө зөвшилцөж шийдвэр гаргах хэрэгтэй гэдгийг анхаарна уу.



---

## Бэлтгэсэн:

---



**Р.Дарханбаяр**  
Хөрөнгө оруулалтын шинжээч

[Darkhanbayar@golomtcapital.com](mailto:Darkhanbayar@golomtcapital.com)  
+976 9490 4321

---

---

**Golomt Capital<sup>®</sup>**

---

